**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 12 сарын 26 өдөр          Дугаар А/474          Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 28.1.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VIII хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоол, IX хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинээр газар эзэмшиж байгаа 3 аж, ахуйн нэгж, байгууллагын нийт 1.1212га /11212м$^2$/ газрыг хавсралтад дурдсанаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа аж, ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА          Ш.ИДЭРБАЯСГАЛАН



671 011 1

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар
сарын 26..-ны өдрийн А/..474.. дүгээр
захирамжийн хавсралт

## ШИНЭЭР ГАЗАР ЭЗЭМШИХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

| № | Иргэний овог, нэр, регистр | Төлөвлөгөөний нэгж талбарын дугаар | Газрын байршил, хаяг | Газрын хэмжээ /м2/ | Газрын зориулалт | Газар эзэмшүүлэх хугацаа | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | “Хөвсгөл ус суваг” ХХК /РД:4140265/ | 2683871 | 1-р баг Баярын талбайн урд талд | 25 | Ус түгээх цэг | 15 | Шинээр газар эзэмших |
| 2 | “Хөвсгөл ус суваг” ХХК /РД:4140265/ | 2683873 | 13-р баг Бүрэнхаан сургуулийн баруун талд | 838 | Ус түгээх цэг | 15 | Шинээр газар эзэмших |
| 3 | “Хөдөөгийн шийдэл” ХХК /РД:4149181/ | 2683875 | 13-р баг РӨНСтанцын зүүн талд | 10349 | Хүлэмж, дарлага | 15 | Шинээр газар эзэмших |

Нийт талбайн хэмжээ:11212м²